

Article

## Монгол улсын боловсролын зорилгыг үнэт зүйлсийн үүднээс шинжлэх нь: 2002, 2023 оны боловсролын хуулиудын жишээн дээр

Эрдэнэдаваа Үүрцайх

*Монгол улс, Улаанбаатар хот, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын сургууль, Боловсролын удирдлагын тэнхим*

\* - Холбоо барих зохиогч: [uurtsaih71@gmail.com](mailto:uurtsaih71@gmail.com)

ORCID – <https://orcid.org/0009-0002-0982-4877>

Хүлээн авсан: 2024.03.02

Засварласан: 2024.05.01

Хэвлэлтэд авсан: 2024.05.30

### Хураангуй

Монголчууд эртнээс өөрийн гэсэн онцлогтой үндэсний үнэт зүйлс болсон төр ёс, түүх соёл, сургалт хүмүүжилд суурилж ирсэн бөгөөд энэ байдал өнгөрсөн зууны эхний хагасаас аажмаар алдагдаж, сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд илүү тодоор илрэх болсон.

Эрх зүйн баримт бичгүүдэд үндэстний үнэт зүйлсийн тогтолцоо алдагдсаны нэг жишээ бол боловсролын хууль дахь зорилгын асуудал юм. Боловсролын хуулийн зорилго бол улс орны хөгжлийг тодорхойлогч хойч үеийн маань дүр байдаг учраас шинэ хуулийн зорилго, үнэт зүйлсийн баримжааг өмнөх хуулийн зорилготой харьцуулж үзэх нь улс орны ирээдүйн хөгжлийг урьдчилан тодорхойлоход чухал үүрэгтэй гэж үзлээ. Тиймээс энэхүү судалгаанд Боловсролын тухай хууль (2002), Бага, дунд боловсролын тухай хууль болон 2023 онд шинээр батлагдаж, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд зорилгыг тодорхойлсон заалтуудыг судалсан. Дээрх хуулиудын зорилгыг тодорхойлсон заалтуудын харьцуулсан шинжилгээний үр дүнгээс харвал хуулийн заалтад орсон категоруудыг үнэт зүйлс (язгуур) ба гэрээ тунхаг, зарчим гэж 2 ангилж болох ба эдгээр нь манай хуулийн зорилгод хэр хэмжээтэй агуулагдаж байгааг харьцуулав. Бодлого судлалын хүрээнд үнэт зүйлс туссан байдлыг Юнескогийн тогтвортой хөгжлийн боловсролын аргачлалд баримжаалан тооцоолсон. Харьцуулсан агуулгын шинжилгээний үр дүнгээс үзэхэд боловсролын хуулиудын зорилгод (2002/2023) хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлс, тунхгуудыг түлхүү тусгасан байх ба мөн үндэсний, язгуур үнэт зүйлсийг уг хуульд тусгах хэрэгцээ шаардлага байгааг илрүүлэв.

**Түлхүүр үг:** Боловсролын хууль · Зорилго · Зарчим · Язгуур үнэт зүйл · Гэрээ тунхаг

### Удиртгал

XXI зуунд ямар боловсрол хэрэгтэй вэ? Өөрчлөгдөж байгаа өнөөгийн нийгмийн шинэ нөхцөлд боловсролын зорилго юу байх вэ? (UNESCO, 2015, р.5) гэж



ЮНЕСКО-ийн ерөнхий захирал асан Ирина Бокова нийт хүн төрөлхтөнд боловсролын талаар чиглүүлэх асуулт тавьсан нь боловсрол, сургалтын зорилгыг анхаарч үзсэн явдал юм. Зорилгын тухай ойлголтын зорилго нь юу вэ? гэсэн асуултаар энэхүү өгүүллийн удиртгал хэсгээ эхлүүлье. Хэзээ нэгэн цагт байшин барихын тулд байгалийн чулуу болоод модыг загварчлах, байшин хэрхэн харагдах талаар ерөнхий архитектурын үзэл баримтлалгүйгээр энд байшингийн тухай ярих боломжгүй юм. Менежментийн ухаанд хэмжигдэхүйц, өнөөдөр ба маргааш, ирээдүйд чиглэсэн, бас хэрэгжих хугацаатай зүйлийг зорилго гэнэ тодорхойлсон байдаг. Энэ утгаараа аливаа зүйлийн зорилго нь ирээдүйн "дүр зураг" болж байдаг.

Монгол улсын боловсролын зорилгын биелэлтийг сүүлийн 20 жилээр хүрээлж үзвэл, Боловсролын тухай хуульд (2002), "Иргэнийг оюун ухаан ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадавхтай болгон төлөвшүүлэхэд оршино" гэж иргэний төлөвшил, хөгжлийг тусгасан боловч боловсролын нийгмийн үр ашиг яагаад буурахад хүрэв? гэсэн асуултад судлаачид "...өнөөдөр манай нийгэмд гарч байгаа хүмүүсийн үйл ажиллагааны гажуудал, доголдол, гэмт хэрэг, зөрчил хариуцлагагүйн зуд нүүрлэсэн байдал, мэргэжилтнүүдийн ажил гүйцэтгэх чадвар сул байгаа зэрэг нь боловсролын үйл ажиллагааны үр дүн туйлын хангалтгүй, түүний бүтээгдэхүүн нь нийгмийн хийгээд хувийн хэрэгцээ хангах чадваргүй байгааг илтгэнэ" (Бэгз, 2017, х.308). Тэрээр шалтгааныг боловсролын үндсэн зорилго болсон иргэний төлөвшилтэй холбож авч үзжээ.

Боловсролын багц хуулийг баталснаас хойш энэ хугацаанд боловсролын хуульд 31 удаа өөрчлөлт орсон, үүнээс бага дунд боловсролын хуульд 14 удаа, дээд боловсролын хуульд 11 удаа, сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд 6 удаа, мэргэжлийн боловсролын хуульд 3 удаа өөрчлөгджээ. Ковид цар тахал гараагүй байх үеийн (учир нь цар тахлын үед дэлхий даяар боловсрол сургалтын үйл явц тасалдсан бөгөөд сургалтын чанарт нөлөөлсөн гэж үздэг) боловсролын тогтолцооны гарцын статистик үзүүлэлтийг судлаач Ж.Энхтүвшин (2022, х.103-104) монгол улсын нийгэм эдийн засгийн хөгжил, өрсөлдөх чадвар, суралцагчдын сурлагын амжилт унасныг: элсэлтийн ерөнхий шалгалтаар /2019/ хамгийн олон шалгуулагчтай монгол хэл бичиг, математик, англи хэл хичээлээр нийт даалгаврын 28-37 нь гүйцэтгэсэн, бүрэн дунд боловсролын чанарын үнэлгээгээр 100 хүүхэд тутмын 63 нь амжилтгүй дүн үзүүлсэн, дэлхийн улс орнуудыг өрсөлдөх чадвараар эрэмбэлэхэд (2020) 63 орноос 61-д орж байна. 2020 оны байдлаар ядуурлын түвшин 27.3 хувь, Монгол улс аз жаргалын индексээр дэлхийн 149 орноос 70 байранд эрэмбэлэгдсэн байна. Боловсролын хууль шинэчлэгдэх хүртэлх боловсролын тогтолцооны гарцын үр дүнг зарим тоон үзүүлэлтээр болон эрдэмтдийн тодорхойлсноор өгүүллээ. Ийнхүү хууль, тогтоомжийн тогтворгүй байдал нь дээрх боловсролын гарцын үр дүн, нийгэм, эдийн засгийн доройтлыг үүсгэж байгаа бөгөөд эцсийн шалтгааныг нь боловсролын хуулийн зорилгоо тодорхойлж чадаагүйтэй холбож авч үзлээ. Хүний ухамсарт аливаа үйл ажиллагаа зорилго тавихаас эхэлдэг ба энэ утгаараа зорилгоо хэрэгжүүлэх, үнэлэх зэргээр өөр хоорондоо холбогдон оршдог. Техник, технологийн хурдацтай хөгжил, өөрчлөлтөд тогтвортой хариу үзүүлэх

зүйл бол өөрийн гэсэн онцлогтой соёл, үнэт зүйлсэд тулгуурласан боловсролын тогтолцоо байх болно.

Боловсролын зорилго ба үндэстний үнэт зүйлийг харьцуулан тусгайлсан судалгаа ховор байна. Боловсролын шинэчлэлийн үйл явцад уламжлал, үндэстний үнэт зүйлсийг хадгалах хандлага хэр байгааг судлах (Чулуунцэцэг, 2019, х.95); Боловсролын бодлогын баримт бичигт үнэт зүйлийн туссан байдлыг судлан шинжлэх хэмжүүр аргачлалыг боловсруулсан туршсан (Сүхболд нар, 2021, х.116). Нийгмийн хөгжлийг чиглүүлэгч, урагшлуулагч боловсрол нь үнэт зүйлд тулгуурлах үндэс нь үнэт зүйлд суурилсан боловсрол (Eidle, W.1993, p.662; Parra, 2013, p.11; Shobha et al., 2015, p.193); ЕБС-д мөрдөгдөж буй түүхийн сургалтын хөтөлбөрт үндэстний үнэт зүйл хэр туссан байдалд шинжилгээ хийж, үндэстнийхээ нэгдмэл үнэт зүйлийг тод томруун тусгах хэрэгцээ шаардлага байгаа (Пүрэв, 2021, х.269). Боловсролын хүрээнд үнэт зүйлсийг сурталчлах, хөгжүүлэх, хувь хүнийг хариуцлагатай, халамжтай, хүн болгон төлөвшүүлэх явдал чухал юм (Halstead, 1996, p.16). Харин үнэт зүйлсийг шууд ба дам байдлаар судалсан судалгаа нэлээд байна. Тухайлбал, Монгол үндэстний шинж, амин чанар, эх оронч үзэл, бахархал, тусгаар тогтнол, монгол хэл, соёл, түүх, зан заншил, оюун сэтгэлгээ, менталитетийг тусгайлан судалсан (Жүгдэр, 1972, х.5-8; Энхтүвшин, 2014, х.115; Баянсан, 2002, х.5-12; Хэрлэн нар 2017, х.1; Мөнх-Эрдэнэ, 2018, х. 86-108). Ийнхүү бид 2002-2023 оныг хүртэл хэрэгжиж ирсэн боловсролын тухай хуулийн зорилго, мөн шинэ хуулийн зорилго дахь үнэт зүйлсийн томъёоллыг тодорхойлоход Юнескогийн тогтвортой хөгжлийн боловсролын аргачлалд тулгуурлан үнэлэх зорилго тавилаа. Дараах асуултуудыг дэвшүүлж байна. ХХI зууны боловсролын хуулийн зорилгод үндэстний язгуур үнэт зүйлс хэрэгтэй юу? Үнэт зүйл ба зөвлөмж, зарчмуудын ялгаа юу вэ? Шинэ хуульд зорилгоо хэрхэн тодорхойлсон бэ? Монгол улс боловсролын зорилгоо цаашид хэрхэн тодорхойлох вэ?

*Боловсролын зорилго ба үнэт зүйлсийн уялдаа холбоо, үүрэг, ач холбогдол:*

Боловсролын зорилго, үнэт зүйлсийн хоорондын уялдаа холбоо алийг нь тэргүүлэх чиглэл болгох нь улс улсын соёлын онцлогоос хамаарч тэдний дундаас гарч ирдэг (International Breau of Education, 1980, х.9) гэж үзсэн бол үнэт зүйлсийг *эцсийн зорилго*, *эцсийн зорилгод хүрэх* арга хэрэгсэл гэж ерөнхийд нь хуваадаг бөгөөд эдгээр үнэт зүйлсийг ач холбогдлын дарааллаар эрэмбэлж, амьдралд баримтлах зарчим болгон ашиглах (Tittler., et al. 2022. p.41), мөн үнэ цэнэ өгөх зүйл, хамгаас үнэтэй чухал зүйл гэсэн *язгуур утга агуулгатай үнэт зүйлийг* олж тогтоох нь үнэт зүйлд суурилсан боловсролын үндсэн асуудал юм (Сүхболд нар, 2021, х.4). Монгол үндэстний үнэт зүйлс, мэдлэг, чадвар, хандлага хийгээд үе үеийн Монгол эх орончдын амин үйл ажиллагааг бүх шатны албан, албан бус, тасралтгүй боловсрол, сургалтын хөтөлбөрт залгамж холбоотой, оновчтой агуулга, арга зүйгээр тусган хэрэгжүүлж, үр дүнг нь тогтмол үнэлж байх нь манай хүүхэд залуусын үндэстний бахархал, хүмүүжил, бүтээлч манлайлалд онцгой ач холбогдолтой (Пүрэв. 2021, х.269) юм. “Бид либерализмыг шүтэж, уламжлалаа гэв (Энхтүвшин, 2022, х.103), “Монгол үндэстний ижилсээ (national indentity) алдаж харийншиж, язгуур үнэт зүйлийнхээ

хомсдолд орж байна” (Пүрэв, 2021, х.254) зэргээр тодорхойлогдоно. Глобал нөлөө, нийгэм, эдийн засгийн хурдацтай өсөлтийн үр дүнд хүмүүсийн үнэлэмж харьцангуй болохын хэрээр уламжлалт үнэт зүйлс нөлөөгөө алдсан нь нийгмийг нэгтгэх хүчийг сулруулж, хүмүүс хоорондоо ойр дотно харилцаа тогтоох, байгальтай холбогдоход хүндрэл учруулсан (Yamanaka, et.al., 2020, p.85). Үнэт зүйл бол нийгэмд удаан хугацааны туршид сайн зүйл гэж хүлээн зөвшөөрөгдсөн суурь итгэл үнэмшил, зан үйл, хандлага юм (Kulem et.al., 2021, p.23). Энэ итгэл үнэмшил, хандлагыг боловсрол, сургалтаар дамжуулж төлөвшүүлэх нь боловсролын үндсэн зорилго болох юм.

*Үнэт зүйлсээрээ хүн ам нь нэгдмэл байхын ач холбогдлыг судлаачид:*

Шинжлэх ухаан, технологийн хөгжлийг уламжлалт үнэт зүйлсээс нэгдүгээрт тавьж байгаа бол үнэт зүйлийн эмгэг үүснэ, уламжлалт үнэт зүйлсийг үл тоомсорлоход аюул, асуудалтай тулгардаг, учир нь уламжлал нь соёлын хөгжилд төрөл, зүйлийн өөрчлөлтөд геном гүйцэтгэхтэй ижил үүрэгтэй бөгөөд уламжлалт үнэт зүйлсийг хадгалах хэцүү ч, шинэ худалдан авалтаас хамаагүй чухал юм (Дождикова, 1998, p.37); Улс орны хувьд үнэт зүйлс нэг ижил байна гэдэг бол аливаа улс орны хөгжлийн гол түлхэц хүч мөн (Хэрлэн, 2020); Сайн сонгосон үндсэн үнэт зүйлс нь удирдамжийн зарчим болдог...Чухал үнэт зүйлсийг тодорхойлж, дараа нь тэдгээрт нийцүүлэн ажиллах нь ил тод байдал, итгэлцлийг хөгжүүлэх үндсийг тавьдаг (Sigurdsson & Stavdal, 2020, p.363); Үндэсний ижилсэл хүчтэй байх нь зөвхөн үндэстнийг нэгтгээд зогсохгүй, авлига, шударга бус явдал буурахад нөлөөтэй (Фукуяама, 2020, х.29); Монгол үндэстний нэгдмэл үнэт зүйлийн тогтолцоог Монголчуудын үндэсний ялгарал, ижилсэл буюу биднийг гадаад байдлаар бусад улс, үндэстнээс ялгаруулж, онцгойруулж буй, дотооддоо биднийг ижилсүүлж, нягтруулж, цул, нэгдмэл болгож байгаа төр, *газар нутаг, хүн ам, удам угсаа түүх, хэл, соёл, ёс заншил хийгээд* бусад үнэт зүйлсийн цогц (Пүрэв, 2021, х.268); Дэлхийд өрсөлдөх зүйл нь тэмдэгт, дохионы системийг хөгжүүлэх, өөриймшүүлэх, олон талт эрдэм, чадвар давамгайлсан байдаг бол харин монголоороо ялгарч үлдэх нь үндэсний соёл, эх хэл, ардын аман билиг сургаалд суурилсан өөрийгөө илэрхийлэх олон талт чадвар (Мөнхжаргал, 2021, х.5) гэжээ.

Глобал түвшинд боловсролын зорилго, зарчмын хөгжлийн чиг хандлага нь “үнэт зүйлсээс олон улсын гэрээ, тунхаг руу” гэсэн шинжтэй байна. Тухайлбал, Юнеско, Боловсролын Олон Улсын байгууллагуудаас гаргаж буй цуврал гэрээ, зарчим, тунхаг, зөвлөмжүүдийг нэрлэж болохоор байна. Энэ бүхэн нь адармаатай гэгч хурдан хувьсан, өөрчлөгдөж буй нийгмийн хөгжлөөс хамаарч бодлогын баримт бичиг дахь эрх зүйн үнэт зүйлийг улс орон бүрээр нарийвчлан оновчтой үндэслэх нь хэцүү болсонтой холбоотой. ЮНЕСКО-оос гаргасан боловсролын бодлогын баримт бичгүүдэд нийтлэг дагаж мөрдөх зөвлөмж, зарчим, үнэт зүйлсийг “Харилцан ойлголцол, Энх тайван, суурь эрх чөлөө, ардчилал, хүний эрх...” (Сүхболд, 2021, х.5), тэгш боломж, насан туршдаа суралцахуй, чанартай боловсрол, ирээдүйгээ хамтдаа төсөөлөхүй зэргээр илэрхийлжээ. Боловсролд хүн төрөлхтний глобал хандлагыг баримтлах шалтгааныг Н.Бэгз (2017, х.187) “Дэлхий дээрх хүний гараар бүтсэн соёлын орчны хөгжил, нээлттэй харилцааны үр дүнд бий болсон шинэ глобал орчинд

өрсөлдөх чадвараа дээшлүүлж чадаагүй улс үндэстэн цаашид бие даан оршин тогтнох боломж улам бүр хумигдах шинжүүд илэрч байна”. Дээрх глобал үнэт зүйлс, зарчмыг манай улс боловсролын ерөнхий хуульд /2023/ тусгахдаа “чанартай боловсрол”, “тэгш боломж”, “насан туршдаа суралцахуй”, “ёс суртахуун”, “сайн зан”-ыг төлөвшүүлэх зэргээр хуулийн зорилгодоо буулгажээ. Энэ мэт бодлогын баримт бичиг ойр ойрхон өөрчлөгддөг байдлыг халах, үр дүнтэй болгох үүднээс боловсролын зорилгыг өөрийн орны соёл, язгуур үнэт зүйлс, дэлхий нийтийн хөгжлийн хандлагыг харгалзан агуулгыг нь зөв тодорхойлох шаардлага байгааг дээр өгүүлсэн онолын зарим хандлага, эрдэмтэн судлаачдын тодорхойлсноос харж болохоор байна. Энэ бүгдийг хураангуйлж харвал дэлхийн улс орнууд нэг хэсэг нь үндэстний онцлог, соёл, уламжлал, давуу хүчин зүйлээ товойлгож боловсролын хуулийн зорилгоо оновчтой тодорхойлсон, нөгөө хэсэг нь нийтлэг зарчим, зөвлөмжийг дагасан, дасан зохицох шинжтэй байгаагаас улс нийгмийн хөгжлийн түвшин хамаарч байна уу гэсэн явцуу дүгнэлт хийж болохоор байна. Өмнө хэлсэнчлэн зорилго бол аливаа үйл ажиллагааны эхэнд (орц), дунд (үйл явц), төгсөлд (гарц) байж хэрэгждэг. Энэ нь нэг талаас боловсролын хуулийн зорилго нь тодорхой байх аваас боловсролын салбар тогтвортойгоор цаашид хөгжих боломж, эх үндэс юм. Боловсролын салбар бусад салбарыг бодвол үр дүнгээ удаан үздэг онцлог салбар юм. Дээрх утгаас харахад боловсрол, сургалтын үр дүн, үр нөлөө, чанарыг сайжруулахад нэн түрүүн зорилгыг оновчтой тодорхойлох, ингэхдээ эрхэмлэх зүйл буюу үнэт зүйлд суурилах, зорилго тодорхой байхаас эхэлнэ гэсэн дүгнэлтийг хийж болно.

Судлаач О.Пүрэв (2023, х.268) үндэсний үнэт зүйл гэдэг нь тэдний түүхэн хувьсал, хөгжлийн явцад бүтээн бий болгосон, өвлөж хөгжүүлж байх ёстой оюун сэтгэлийн болон эдийн дээд эрхэмлэх зүйлийн цогц бөгөөд хүмүүс үндэснийхээ үнэт зүйлд итгэдэг, зан үйл, сурч боловсрохдоо сэдэл, удирдлага болгодог гэжээ. Иймд бид үндэсний гэсэн бүхнээсээ суралцах нь глобал ертөнцөд амьдрах монгол хүн, дотооддоо нэгдмэл “Монгол иргэн”-ийг төлөвшүүлэхэд үндэсний язгуур үнэт зүйлс болоод хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсийг хослуулах нь зүйтэй юм.

### Хүснэгт 1

#### Монгол улсын боловсролын хуулиудад зорилгыг тодорхойлсон байдал

Хууль	Зорилго /заалт/
-Боловсролын тухай хууль (2002, 4.1)	“Иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадавхтай болгон төлөвшүүлэхэд оршино”

-Бага, дунд боловсролын тухай хууль (2002, 2.1)	“Бага боловсролын зорилго нь эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай монгол хүүхэд төлөвшүүлэх, суурь боловсролын зорилго нь амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх, бүрэн дунд боловсролын зорилго нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэхэд тус тус оршино”
-Боловсролын ерөнхий хууль (2023, 4.1)	“Монгол улсын боловсролын зорилго нь хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэхэд оршино”
-Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль (2023, 3.2)	“Ерөнхий боловсролын зорилго нь суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж, ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэхэд оршино”

### Судалгааны материал, арга зүй

Боловсролын хуулийн зорилгод үнэт зүйлс туссан байдлыг Юнескогийн тогтвортой хөгжлийн боловсролын аргачлалд (McKeown et al., 2002, p.100-124) баримжаалан тооцооллоо. Энэ нь бодлогын баримт бичигт судалгаа, шинжилгээ хийдэг аргачлал юм.

2017 онд Удирдлагын академийн судлаач Б.Хэрлэн нарын эрдэмтэд Шварцын аргачлалаар (шинжлэх ухаанч, найдвартай, нийтлэг шинжүүрээр) өнөөгийн монголчуудын үнэт зүйлсийн тодорхойлох далайцтай судалгаа хийжээ. Энэхүү судалгааны найдвартай байдал зэргийг харгалзан үр дүнг бид энд ашиглав.

### Хүснэгт 2

Боловсролын хуулиудын зорилгод үнэт зүйлийн туссан байдлыг шинжлэх хэмжүүр, аргачлал

	Тодорхойлогч	Шалгуур	Хэмжих шкал
1	Бусдад санаа тавих	Шударга зан	1/0
		Чин үнэнч нөхөрлөл	1/0
		Үнэнч байдал	1/0
		Хариуцлагатай байдал	1/0
		Хайр халамж	1/0
		Уучлах сэтгэл	1/0
		Тусч байдал	1/0
		Оюун санааны амьдрал	1/0
		2	Эрх мэдэл, амжилт
		Удирдах эрх мэдэл	1/0
		Эд баялаг	1/0
		Нөлөөтэй байдал	1/0
		Нийгэмд танигдсан байдал	1/0

		Амжилттай байдал	1/0
		Нэр хүндээ хамгаалах	1/0
		Ухаалаг байдал	1/0
		Чадвар, чадавх	1/0
		Амбиц хувийн тэмүүлэл	1/0
3	Аюулгүй байх	Эрүүл мэнд	1/0
		Нийгмийн дэг журам	1/0
		Гэр бүлийн амар жимэр	1/0
		Холбоо хамаарлаа мэдэх	1/0
		Харилцан тустай байх	1/0
		үндэсний аюулгүй байдал	1/0
		Цэвэрч нямбай	1/0
		Нийгмийн шударга ёс	1/0
		Энхтайван	1/0
4	Универсализм	Байгаль орчноо хамгаалах	1/0
		Эрх тэгш байдал	1/0
		Эх байгальтайгаа нэгдмэл	1/0
		Дотоод амар амгалан	1/0
		Уужуу холч ухаан	1/0
		Мэргэн ухаан	1/0

Монгол улсын боловсролын тухай хууль, боловсролын ерөнхий хууль болоод бага дунд болон ерөнхий боловсролын хуулийн зорилгод дээрх үнэт зүйлс туссан байдлыг хэмжээсжүүлэхдээ хуулийн зорилгод туссан давтамжийг нь авч үзэв.

### Судалгааны үр дүн ба хэлэлцүүлэг

Жишээлсэн судалгааны (case study) үр дүнгээр Монгол улс боловсролын зорилгоо үг хэллэг, утгын агуулгын хувьд ч оновчтой тодорхойлж чадаагүй байна. Учир нь Монгол улсын боловсролын зорилгыг хөрш зэргэлдээ улс орнуудын боловсролын зорилготой харьцуулсан жишээгээр манай улс зорилгоо үнэт зүйлсийн хувьд оновчтой болгох, мөн амьдралд ойртуулахын тулд зарчмуудыг тоочих биш, найруулгын хувьд оновчтой тодорхойлох явдал юм. Тухайлбал, үйл үг, тэмдэг нэрээр дэлгэрүүлэх, үндэстний үнэт зүйлсийн судалгааг нарийвчлан тодорхойлох, зорилгоо тэмүүлэлтэй гаргах зэрэг хэрэгцээ харагдаж байна.

2002 оноос боловсролын харилцааг зохицуулж байсан боловсролын тухай хуулийн зорилго, бага, дунд боловсролын тухай хуулийн зорилго, мөн 2023 онд шинээр батлагдан мөрдөгдөж буй хуулиудаас Боловсролын ерөнхий хуулийн зорилго, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн зорилгод үндэстний үнэт зүйлс хэрхэн туссан байдал, мөн шинэ, хуучин хуулийн үнэт зүйлсийн уялдаа холбоо болон өөрчлөлтийг харахын тулд үнэт зүйлсийг харьцуулан шинжилснийг (хүснэгт 4) харуулав.

## Хүснэгт 3

Монгол хүний үнэт зүйлс ба боловсролын хуулиудын харьцуулалт

Үнэт зүйлс (заалт)	БТХЗ	БЕХЗ	БДБЗ	СӨЕБЗ
<i>Бусдад санаа тавих</i>				
Шударга зан		1	1	1
Чин үнэнч нөхөрлөл				
Үнэнч байдал				
Хариуцлагатай байдал				1
Хайр халамж				
Уучлах сэтгэл				
Тусч байдал				
Оюун санааны амьдрал				
<i>Эрх мэдэл, амжилт</i>				
Нийгмийн байр суурь				
Удирдах эрх мэдэл				
Эд баялаг				
Нөлөөтэй байдал				
Нийгэмд танигдсан байдал				
Амжилттай байдал				
Нэр хүндээ хамгаалах				
Ухаалаг байдал				
Чадвар, чадавх	1	1	1	1
Амбиц, хувийн тэмүүлэл				
<i>Аюулгүй байдал</i>				
Эрүүл мэнд				
Нийгмийн дэг журам				
Гэр бүлийн амар жимэр				
Холбоо хамаарлаа мэдэх				
Харилцан тустай байх				
үндэсний аюулгүй байдал				
Цэвэрч нямбай				
Нийгмийн шударга ёс	1			
Энх тайван				
<i>Универсализм</i>				
Байгаль орчноо хамгаалах				
Эрх тэгш байдал		1		
Эх байгальтайгаа нэгдмэл				
Дотоод амар амгалан				
Уужуу холч ухаан				
Мэргэн ухаан				

*Тайлбар: БТХЗ - Боловсролын тухай хуулийн зорилго, БЕХЗ - Боловсролын ерөнхий хуулийн зорилго, БДБЗ - Бага дунд боловсролын зорилго, СӨЕБЗ - Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын зорилго*

Уг харьцуулалтаас (Хүснэгт 3) харахад тухайлбал, ёс суртахуун гэсэн заалт нь бага, дунд боловсролын тухай хууль (бусдад санаа тавих гэсэн нэгдүгээр фактор



дахь агуулгууд ёс суртахууны аль нэг шинжээр нь тусгагдсан)-аас бусад хуулийн зорилгод тусгагдсан бол *эрх мэдэл, амжилт* гэсэн хоёрдугаар фактор дахь “чадвар, чадавх” нь эдгээр бүх хуулийн зорилгод тусгагджээ. Хувь хүний мэдлэг, чадвар, чадавх гэсэн хуулийн заалтын давхцалаас харахад эрх мэдэл, амжилтыг чухалчилсан нийгмийн хэрэгцээ, шаардлага одоо байгаа юм байна гэсэн дүгнэлтийг өгч болохоор байна. Учир нь чадвар чадавх, нэр хүнд, байр суурь, нөлөөтэй байх, амжилттай байдал зэрэг нь хувь хүний байр, суурийг бэхжүүлэхэд чиглэсэн үнэт зүйлс (Хэрлэн нар, 2017, х.46) бөгөөд хоёрдугаарт эрэмбэлэгдсэн эдгээр үнэт зүйлсийг дээрх хуулиудын зорилгод чухалчилжээ.

Харин боловсролын үр дүнгийн талаар удиртгал хэсэгт өгүүлсэн онолын чанартай тодорхойлолтуудаас харахад хамгийн их учир дутагдалтай байсан “хариуцлагатай байдал”, “нийгмийн шударга ёс”, “эрх тэгш байдал” зэрэг нь заримд нь (Боловсролын тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон дунд боловсролын тухай хууль) нэг, нэг удаа дурдагдсан бол язгуур Монгол хүний чанарууд эдгээр хуулийн зорилгод дурдагдаагүй цаад учир шалтгаан юу вэ, цаашлаад нийгмийн зан үйлд үзүүлэх үр дагавар юу вэ гэсэн асуултын хариулт нь өнгөрсөн 20 жилийн хугацааны нийгмийн амьдралын түвшин бэлхнээ харуулж буйг өмнө өгүүлсэн.

Бидэнд хамгийн чухалд тооцогдох факторт (3) хамаарах; эрүүл мэнд, нийгмийн дэг журам, гэр бүлийн амар жимэр байдал, холбоо хамаарлаа мэдэх, харилцан тустай байх, үндэсний аюулгүй байдал, цэвэрч нямбай, нийгмийн шударга ёс, универсализм факторт (4) хамаарах; Монгол хүний сайхан сэтгэл, бие биеэ хайрлах, хүнлэг сэтгэл, хүний мөс жудаг, уужуу холч ухаан, дотоод амар амгалан, байгаль дэлхийгээ аминчлах сэтгэлгээ зэрэг үнэт зүйлсийг эдгээр хуулийн заалтад тусгагдаагүй байна. Уг шалтгааныг язгуурын үнэт зүйлд бус либерал үзэл баримтлалд тулгуурласан хууль, эрх зүйн заалтаас эхтэй талаар нэг бус судлаачид (Хэрлэн, 2023, х.1; Энхтүвшин, 2022, х.103) өгүүлсэн байдаг. Дээрх бүх шалтгаанууд шинэ хуулийн зорилгыг эргэж харах, сайжруулахыг харуулж буй хэрэг билээ. Хураангуйлж үзвэл эдгээр хуулийн зорилгод мэдлэг, оюун ухааны чадвар чадавх, шударга зан зэргийг эрхэмлэсэн бол хариуцлагатай байдал, нийгмийн шударга ёс, эрх тэгш байдал зэргийг зарим хуулийн зорилгод дурджээ. Ерөнхийдөө үндэсний онцлогтой үнэт зүйлсийн хувьд учир дутагдалтай байгаа нь харагдана.

Үүнтэй холбогдуулж хөгжлөөрөө тэргүүлэгч Хятад, Солонгос, Япон зэрэг орнуудын боловсролын зорилгод үндэстнийх нь язгуур үнэт зүйлс орсон практик жишээг харж болно. Тухайлбал, Бүгд найрамдах Солонгос улсын боловсролын хуулийн зорилгод үндэстний үнэт зүйл туссан байдлыг харвал “*Хонгик Инган*”-ийн үзэл суртлын дагуу бүх иргэдэд өөрсдийн зан чанарыг төлөвшүүлэх (Choi Moon-Hyoung, 2009, p.177) гэсэн нь өөрсдийн домгоос гаралтай үндэсний үзэл санааг оруулсан байна.

Япон улсын хувьд Бушидо ёсонд үндэслэн ёс суртахуун, хариуцлагатай байдлыг чухалчилсан гэж судлаачид үздэг. “Бие, сэтгэлээрээ төгс төгөлдөрт хүрэхийг зорих...”, “...*Амгалан тайван япон улс* болоод *нийгмээ дээдэлсэн улс үндэстнийг төлөвшүүлэх*” зэргээр “Боловсролын бодлого нь уламжлалт үнэт зүйлст бат бэх суурилах болжээ” (Чулуунцэцэг, 2019.х.98) зэргээс харахад

дорно дахины ард түмний баримталдаг “дотоод сэтгэлийн амар амгалан” байдлыг тунхаглажээ гэж үзэх үндэстэй.

БНХАУ-ын боловсролын хуульд “*Мао Зэдуны үзэл*”-д тулгуурлаж, “*хятадын онцлогтой социализм байгуулах*” явдал бөгөөд, “*хятад үндэстний түүх, соёлын гайхамшигт уламжлалыг өвлөн*”... “*ёс суртахуун, оюун ухаан, бие бялдрын хувьд хөгжсөн*”, “*социализмын үйл хэргийг залгамжлагч*”, “*бүтээн байгуулагчдыг төлөвшүүлэх*” зэрэг болно. Дээрх жишээнд дурдагдсан улс орнууд боловсролын үр шимийг хүртэж, хүний хөгжил, эдийн засгийн үзүүлэлтээрээ эхэн хэсэгт явааг бид бүхэн мэднэ.

#### Хүснэгт 4

Боловсролын тухай болон боловсролын ерөнхий хуульд үнэт зүйлсийн тусгасан байдлын харьцуулсан шинжилгээ

Хууль	БТХЗ /2002/	БЕХЗ /2023/
Баримжаа болгосон зарчим, үнэт зүйлс	Оюун ухааны чадавхтай	Чанартай боловсрол
	Ёс суртахууны зохих чадавхтай	Ёс суртахуунтай
	Бие бялдрын зохих чадавхтай	Сайн зан чанар
	Хүмүүнлэг, энэрэнгүй байдал	Тэгш боломж
	Бие даан суралцах, ажиллах, амьдрах	Насан туршдаа суралцахуй

Боловсролын ерөнхий болон боловсролын тухай хуулийн зорилгыг харьцуулан үзэхэд “ёс суртахуун” гэсэн үнэт зүйл давхцаж байгаа бол, харин мөн боловсролын гол уриа болсон “хүмүүнлэг”, энэрэнгүй ёс, хүний хамгийн эрхэм баялаг болох “бие бялдар” (эрүүл чийрэг)-ын хөгжлийг орхигдуулсан байх жишээтэй байна.

Монгол улсын боловсролын хуулийн зорилгыг энэ хэсэгт хамаатуулж сүүлийн 30 жилээр урагшлуулан сөхөж үзвэл Монгол улсын шинэ үндсэн хууль (1992), 1991, 1998, 2002 онд шинэчлэгдсэн боловсролын хуулийн зорилгод хүмүүнлэг, энэрэнгүй ёсыг тусгасан бөгөөд 2023 оны боловсролын тухай хуулийн зорилгод дээрх үнэт зүйлийг орхигдуулсан байгаа нь учир дутагдалтай байна. Монголчуудын үнэт зүйлсийн судалгаагаар бусдад санаа тавих гэсэн факторыг нэгдүгээрт эрхэмлэсэн байгаа нь үүнтэй шууд хамраалтай гэж дүгнэж болох билээ. Гэтэл шинэ хуулийн зорилгод үүний оронд сайн зан чанар гэсэн нэр томъёог оруулсан байгаа нь хүмүүнлэг, энэрэнгүй ёсыг төлөөлөхгүй юм. Учир нь хүн төрөлхтөн тодорхойгүй ямар ч ирээдүй рүү алхсан байлаа гэхэд боловсролын хамгийн түрүүн баримтлах зарчим бол хүмүүнлэг, энэрэнгүй байдал юм. Өөрөөр хэлбэл хүмүүнлэг, энэрэнгүй байдал нь ёс зүй ба ёс суртахууны зарчмууд, хүчирхийлэл, үл тэвчих, ялгаварлан гадуурхах үзлийн эсрэг зогсож байдаг (UNESCO, 2015, p.12), боловсролын зорилго нь хүмүүнлэгийн ухаан, шинжлэх ухаан, технологийг нэгтгэж, дэлхий даяар хүний тухай ойлголтын олон талт байдал, олон талт байдлыг харгалзан үзэх соёлын үзэл баримтлал дээр суурилсан орчин үеийн хүний үзэл баримтлалын загвар юм (International Breau of Education, 1980.х.12). Вилхелм Фон Хумболдт үзсэнчлэн хүнлэг энэрэнгүй (гуманистический) үзэл санааны үүднээс боловсрол нь хүний

бүхий л хүчин чадлыг өдөөж, ингэснээр хорвоо ертөнцийг эзэмдэх явцдаа хөгжин, бие даасан бодгаль individuality, бие хүн (personality) болоход хүргэнэ, боловсролын тогтолцоонд хүнлэг энэрэнгүй юу? Эсвэл үр дүнд чиглэсэн үү? гэсэн хоёр асуултаас тухайн үндэстний боловсролын шийдвэрүүдийн чин хандлага гарч ирдэг (Бернхард Нагел 2017, х.56). Эдгээр тодорхойлолтуудаас бид боловсролын сүүдэр ч хүмүүнлэг байх явдал юм гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна.

Монгол ардын аман зохиолд эрүүл бие, бялдрыг “дайн баатар далайд усч” (Баттулга, 2013, х.9), “дээд эрдэнэ эрүүл мэнд, дунд эрдэнэ эрдэм, доод эрдэнэ баян”, “эрүүл биед саруул ухаан оршино”, “эрүүл явбал ирэх жилийн улсын наадмыг үзнэ” гэж гэхчлэн хэлэлцэж ирсэн. Эндээс дүгнэвэл эрүүл, энх аж төрөх нь хүний амин хувийн хэрэг төдий бус, улс нийгмийн хэрэг болох нь харагдана. Мөн эрүүл, чийрэг бие бялдар, саруул ухаан, цэвэр ёс суртахуун гэсэн ойлголтуудыг нэг нэгнээс салгах боломжгүй хүний эрхэм нандин зүйлүүд болохыг харж болохоор байна.

Боловсролын хуулийн зорилгыг нэр томъёоны хувьд тодруулах шаардлагыг хэл шинжлэлийн эрдэмтэн Ч.Баттулгын (2013.х.10) жишээлснээр тодруулбал, Япон улс боловсролын үндсэн хуулийн зорилгоо “өв тэгш мэдлэгтэй”, “цэвэр ариун ёс суртахуунтай”, “эрүүл чийрэг бие бялдартай”, төгөлдөр хүнийг төлөвшүүлэхэд чиглэгдэнэ гэж нэг бүрчлэн нэр томъёог тодотгож өгчээ. Гэтэл манай боловсролын ерөнхий хууль болон бусад хуулиудын зорилгод (2023) зарчмуудыг өмнөх хуулийн адилаар шууд тоочиж өгүүлсэн. Ингэж оруулахын сул талыг судлаачид боловсролын зорилго дахь үнэт зүйлс, зарчим, тунхгууд нь бараг нэвтэрхий толь бичигт байдаг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй, тэдгээр нь хүний амьдралын ихэнх хэсэгт маш өндөр хүсэл, эрмэлзэл агуулсан ойлголтууд байдаг. Тухайлбал, Хүмүүнлэг, ёс суртахуун, эв нэгдэл, шударга ёс, ардчилал, хүний эрх, өсөлт хөгжил, хүмүүжил, төлөвшил зэрэг нь зохиомол утга бүхий ирээдүйн боломжит төсөөлөл байдаг ба энэ утгаараа суралцагчдад бүрхэг хэвээр үлддэг. Тэгэхээр тодорхой, оновчтой, түүнийг хэрэгжүүлэх бодит арга замыг санал болгох ёстой. Ямар нэгэн удирдамж, тайлбар хэрэгтэй (International Bureau of Education, 1980, p.10) хэмээх дурджээ. Өөрөөр хэлбэл дээрх бүх зарчмууд нь Япон улсын тодорхойлсончлон хэмжүүртэй (ямар гэсэн асуултад хариулагдах) байх ёстой.

2002 оноос 2023 оны 7 сар хүртэл мөрдөгдсөн боловсролын тухай хуулийн зорилгын утга, агуулгыг (ирээдүйд Монгол улсыг авч явах, хөгжүүлэх иргэнийг) төсөөлбөл: “Иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдын зохих чадавхтай...” гэсэн нь ёс суртахуун, бие бялдар, оюун ухааны хувьд “дундаж”, гэсэн логик утга харагдана. Зохих хэмээх үгийн утга нь Монгол хэлний их тайлбар тольд (1). Зүй ёсонд нийцэх, (2). Юмны эв зүй таарах гэсэн бөгөөд “тохирох”, “таарах”, “нийцэх” гэсэн утга нь бүрэн дүүрэн, төгс төгөлдөр гэсэн утгыг илэрхийлэхгүй аж, дээрхийг ерөнхийлж үзвэл “дэлхийн дундаж монгол хүн” болох бөгөөд түүнд хүрсэн нь цөөн байгааг судалгааны үр дүнгүүд бэлхнээ илтгэнэ. Энэ бол зорилгыг “хүн төвтэй”-ээр авч үзэж буй хандлага юм.

Бид боловсролын талаар олон улсын байгууллагаас гаргадаг илтгэлүүд нь суурь гэрээ, зөвлөмж гэдгийг анхаарах хэрэгтэй байна. Тиймээс олон улсын илтгэл,

зөвлөмжийг дагнаж хуулийн зорилгод шууд тусгаж, тунхаглах нь үндэсний соёл, үнэт зүйлийг орхигдуулдаг болохыг онолын хэсэгт дурдсан. Энэ нь эгалитарист (бүхнийг тэгшитгэх, ижил байлгах) үзэл санаа юм.

Диалектикийн хуулиар бол хөгжил байгаа бол хөдөлгөөн байна. Хөдөлгөөн бол өөрчлөлт бөгөөд юмсын орших шинж юм (Хавх, 2006, х.32). Үүнтэй адилаар нийтлэг үнэт зүйлс болоод зөвлөмжүүдийн хувьсамтгай байдал нь соёл, эдийн засаг, улс төрийн хувьд нийгмийн байнгын өөрчлөлтийн үр дүн бөгөөд энэ үр дүнгийн нөлөөнд үнэт зүйлсийн тогтолцоо ер бусын өөрчлөгдөж, гажууддаг (Kelum A.A. Gamage. et.al., 2021, p.23). Монгол улсын боловсролын ерөнхий хуулийн зорилгод (өмнөх хуулиудад мөн адил тусгасан) ЮНЕСКО-оос гаргасан зөвлөмжүүд болох “чанартай боловсрол”, “Тэгш боломж”, “Насан туршдаа суралцах” зэрэг зарчмуудыг ийнхүү шууд тусгажээ (хүснэгт 4).

### Хүснэгт 5

Ерөнхий боловсролын хуулийн зорилгод үнэт зүйлс тусгагдсан байдлын харьцуулалт

Хууль	БДБЗ	СӨЕБЗ
	<i>Бага боловсрол:</i>	<i>Ерөнхий боловсролын зорилго нь:</i>
	-Эх хэл, соёл	-Бие даан сурах, амьдрах
	-бүтээлч	-Мэдлэг, чадварыг хөгжүүлэх
	-Сурах арга барилтай	-Ёс суртахуунтай
	-Монгол хүн	-Хариуцлагатай
Баримжаалсан үнэт зүйлс (зорилгод орсон эрэмбээр жагсаав)	<i>Суурь боловсрол:</i>	-Ажил мэргэжлийн чиг баримжаа
	-Амьдрах ухаан	-Иргэн төлөвшүүлэх
	-Шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар	
	-Бие даан суралцах	
	-Иргэн төлөвшүүлэх	
	<i>Бүрэн дунд боловсрол:</i>	
	-Мэдээлэл боловсруулах	
	-Өөрийн үзэл бодолтой	
	-Суралцах чадвар	
	-Мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай	
	-Иргэн төлөвшүүлэх	

Дээрх (Хүснэгт 5) харьцуулалтаас харахад 2002 оны бага, дунд боловсролын хуульд, бага ангид нь монгол хүн болгож төлөвшүүлнэ, дунд ангид нь иргэн болж төлөвшүүлнэ, ахлах ангид ч бас өөрөөр нэг хүнийг төлөвшүүлэх гэж тодорхойлсон мэт харагдана. Өөрөөр хэлбэл боловсрол сургалтад анхаарах зүйл нь нас насны хүүхдийн танин мэдэхүй, сэтгэл зүйн онцлог бөгөөд дидактик арга зүйн зарчмаар ялгаатай ч хүрэх үр дүн нь монгол хүнийг төлөвшүүлэх, хөгжүүлэх явдал юм. Энэ бол зорилгыг хүн төвтэйгөөр, боловсролын тогтолцоонд нь авч үзэж буй хэрэг билээ. Харин шинэ хуульд Бат, Цэцэг нар бага ангидаа ч тэр, дунд ангидаа ч тэр, ахлах ангид ч тэр боловсролын үндсэн зорилгын дагуу насан туршдаа суралцаж, төлөвшинө гэж боловсролын хуульд

(Бага, дунд боловсролын тухай хууль, 2023) заасан нь сайшаалтай ч, Монгол хүн болж төлөвшихөд гол нөлөөтэй үндэсний язгуур шинж, соёл, үнэт зүйлээрээ нэгдмэл байх тухай заалт оруулаагүй нь учир дутагдалтай бөгөөд боловсрол сургалтыг үнэт зүйлстэй уяж өгөх хэрэгцээ, шаардлага байна гэж үзлээ.

#### Хүснэгт 6

Шинээр батлагдсан Боловсролын ерөнхий хууль” болон “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хууль”-ийн зорилгын уялдаа холбоо

Хууль	БЕХЗ	СӨЕБЗ
Баримжаалсан	<i>Монгол улсын боловсролын зорилго:</i>	<i>Ерөнхий боловсролын зорилго:</i>
үнэт зүйлс,	-Чанартай боловсрол	-Бие даан сурах, амьдрах
зарчмууд	-Ёс суртахуунтай	-Мэдлэг, чадварыг хөгжүүлэх
	-Тэгш боломж	-Ёс суртахуунтай
	-Сайн зан чанар	-Хариуцлагатай
	-Насан туршдаа суралцахуй	-Ажил мэргэжлийн чиг баримжаа
	-Иргэн төлөвшүүлнэ	-Иргэн төлөвшүүлэх

Дээрх харьцуулалтаас үзвэл, бие даасан, насан туршдаа суралцахуй, ёс суртахуун, иргэн төлөвшүүлэх зэргийг чухалчилж үзсэн бол мэдлэг чадварыг хөгжүүлэх, ажил мэргэжлийн баримжаа зэргээр хуулийн зорилгод агуулга, утга ижил байдал ажиглагдаж байна. Уялдааны хувьд ерөнхийдөө гол чигээ алдаагүй тодорхойлсон боловч хоёр хуулийн зорилгод бусад хуулийн адил язгуур үнэт зүйлс ба бүтээлч, тэмүүлэлтэй байх гэсэн үндсэн шалгуураар бол учир дутагдалтай байна. Бид сургалтын хөтөлбөрийн агуулга, залгамж холбоог ярьдаг ч боловсролын зорилгынхоо уялдааг бага ярьж ирсэн.

#### Дүгнэлт

Монгол улсын Боловсролын ерөнхий хуулийн зорилгыг өмнө үйлчилж байсан хуультай нь харьцуулах, мөн судалгаагаар тодорхойлогдсон монголчуудын үнэт зүйлстэй угталцуулж, үнэт зүйлсийн давтамж, өөрчлөлтийг нь харав. Судалгааны үр дүнгээс харахад шинээр батлагдсан боловсролын хуулийн зорилгод үндэстний язгуур үнэт зүйлс бага туссан, харин боловсролын олон улсын байгууллагуудаас гаргадаг гэрээ, зөвлөмж, зарчмуудыг түлхүү оруулжээ. Тиймээс бид энэхүү судалгаанд Монгол улсын Боловсролын ерөнхий хуулийн зорилгод суралцагчдыг Монгол хүн болгон төлөвшүүлж, хөгжүүлэхэд шаардагдаж буй үнэт зүйлсийг тодорхойлон авч үзсэнээрээ ач холбогдолтой хэмээн үзэв. Учир нь даяаршиж буй хөгжлийн энэ цагт улс орны цаашдын хувь заяанд иргэд нь өөрийн үндэсний үнэт зүйлс, менталитетаар ижилсэх, бусдаас түүгээрээ ялгарах, онцгойрох нь улс орны боловсролын бодлогын дотоод асуудал бөгөөд эртнээс нааш улс үндэстнүүд үүндээ анхаарч ирсэн нь харагдана. Ийм учраас боловсролын хуулийн зорилго нь дан ганц философи сэтгэлгээ, маргаанаас урган гарсан хийсвэр санаа, хоосон тунхаглал, эсвэл шийдвэр гаргаж баталдаг улс төрчдийн дутуу, хуумгай шийдвэрүүдийн нийлбэр байж болохгүй, харин боловсролын тогтолцоо тэнцвэртэй байхын тулд

боловсролын ерөнхий хуулийн зорилго нь бусад багц хуулиудынхаа зорилгыг нэгтгэн байх учиртай. Бидний энэхүү судалгаагаар Монгол улсад хэрэгжсэн үе үеийн боловсролын хуулиудын зорилгын үзэл санааны үнэт зүйлс нь дотоод агуулгаар нэгдлээ олоогүй байна гэж үзлээ. Иймд уг хуулийн зорилгод үндэсний язгуур соёл, үнэт зүйлсийг бахархалтайгаар оруулах, дэлхийд өрсөлдөх “Монгол хүн”, “Монгол иргэн” гэж хэн бэ гэдгийг тодруулах, улмаар төлөвшүүлэх хэрэгцээ, шаардлага байна.

### **Ашигласан бүтээлийн жагсаалт**

- Баттулга, Ч. (2013). Боловсролын зорилгыг тодорхойлох асуудалд. *Боловсрол судлал сэтгүүл*, 9 (97), 8-12
- Бренхард, Нагел. (2017). Боловсрол дахь бодлогын сонголт. *Орчин үеийн боловсролын бодлого, менежмент, Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл*, 1, 23-31
- Бэгз, Н. (2017). Монголын боловсрол судлалын шинэ парадигм. Улаанбаатар: Соёмбо Принтинг ХХК
- Мөнхжаргал, Д. (2021). Боловсролын хуулийн амин шүншиг. *Нээлттэй сургууль сонин*, МУБИС, 11 (244), х.5
- Мөнх-Эрдэнэ, Л. (2018). Тэргүүнгүй төр. Улаанбаатар: Степпе паблишинг
- Пүрэв, О. (2021). Монголын боловсрол, сургалтыг хүмүүншүүлэх онол, арга зүй. Улаанбаатар: Мөнхийн үсэг
- Сүхболд, Б., Жадамба, Б., Алтангоо, О. (2021). *Үнэт зүйлийг нэг ертөнцийн хандлагын үүднээс шинжихүй*. Улаанбаатар: МУБИС хэвлэх үйлдвэр
- Фрэнсис Фукуяама, (Орч:Д. Баярхүү). (2020). *Танигдахуй: Нэр төрийн хэрэгцээ ба гомдлын улс төр*. Улаанбаатар: Нерко паблишинг
- Хавх, Н. (2006). Буддын сурган сэтгэл судлал, хүмүүжлийн гүн ухаан, Улаанбаатар: Битпресс
- Хэрлэн, Б., Түдэв, Ш., Санжмятав, Ч. (2017). Монголчуудын үнэт зүйлсийг Шварцийн аргачлалаар тодорхойлсон нь. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК
- Чулуунцэцэг, Э. (2019). Монгол улсын бүрэн дунд боловсролын зорилго, уламжлал, шинэчлэл: Эрх зүйн баримт бичгийн шинжилгээ. *Лавай сэтгүүл*, 15(22), 95-100.
- Бага дунд боловсролын тухай хууль, (2002.05.03). УИХ, Улаанбаатар, 2.1 <https://legalinfo.mn/mn/detail/72>
- Монгол Улсын боловсролын тухай хууль, (2002.05.03), УИХ, Улаанбаатар, 4.1 <https://legalinfo.mn/mn/detail/9020>
- Монгол Улсын боловсролын ерөнхий хууль, (2023.07.07), УИХ, Улаанбаатар, 4.1 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759958962301>
- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, (2023.07.07), УИХ, Улаанбаатар, 3.1 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759959012931>
- Энхтүвшин, Ж. (2022). Боловсролын парадигм: Онол ба практик. *Боловсролын тулгамдсан асуудал, шийдэл, ЭШХ-ын эмхэтгэл*, 7, 103-112.

- Дождикова, Р.Н.К вопросу об аксиологических основаниях обыденного познания // *Вопросы философии*. 2021. Т. № 2. С. 33-42.
- Tittler, M.V., Lannin, D.G., Han, S. *et al.* Why personal values matter: values, colorblindness, and social justice action orientation. *Curr Psychol* 41, 5075–5087. doi: <https://doi.org/10.1007/s12144-020-01006-6>
- Eidle, W. (1993). Values, Education and Self-Esteem. *Education*, 113 (4), 661-671.
- Sundaresan Shobha, Nandakumar Kala, Value Education towards Empowerment of Youth-A Holistic Approach, *Procedia - Social and Behavioral Sciences*, 172(2015),192-199. doi. <https://doi.org/10.1016/j.sbspro.2015.01.354>.
- Parra, S. (2013). Exploring the Incorporation of Values for Sustainable Entrepreneurship Teaching/Learning. *Journal of Technology Management & Innovation*, 8(1), 11–20. doi: <https://doi.org/10.4067/S0718-27242013000100002>
- Kelum, A. A. Gamage. (2021). The Role of Personal Values in Learning Approaches and Student Achievements. *Behavioral Sciences*. 11(7):102.
- International Bureau of Education, (1980). *Studies and surveys in comparative education*. Paris: UNESCO.
- Sigurdsson, J. A., Beich, A., & Stavdal, A. (2020). Our core values will endure. *Scandinavian Journal of Primary Health Care*, 38(4), 363–366. doi: <https://doi.org/10.1080/02813432.2020.1842676>
- Choi, Moon-Hyoung. (2009). The Concept of God in the Idea of Hongik ingan *The Review of Korean Studies*. (12), 177-196  
<https://api.semanticscholar.org/CorpusID:147640938>
- Mckeown, Rosalyn., Hopkins, A., Rizzi, R., Chrystal bridge, M, (2002). Education for sustainable development toolkit. *Energy, Environment and Resources Center*. Paris: UNESCO.
- UNESCO. (2015). Rethinking Education: Towards a global common good?. Paris
- Yamanaka, S., Suzuki, K.H. (2020). Japanese Education Reform Towards Twenty-First Century Education. In: Reimers, F.M. (eds) *Audacious Education Purposes*. Springer, Cham.  
[https://doi.org/10.1007/978-3-030-41882-3\\_4](https://doi.org/10.1007/978-3-030-41882-3_4)

## Analyzing the purpose of education in Mongolia from value-orientation system: on the example of the education laws of 2002 and 2023

Erdenedavaa Uurtsaikh

*Doctoral student in Educational Administration, School of Education Studies, University of Education, Ulaanbaatar, Mongolia*

Corresponding author: [uurtsaih71@gmail.com](mailto:uurtsaih71@gmail.com)

ORCID: <https://orcid.org/0009-0002-0982-4877>

---

Received: 2024.03.02

Revised: 2024.05.01

Accepted: 2024.05.30

---

### Abstract

Mongolians have long been based on their own unique national values, such as polity, history, culture, and education. An example of the loss of the nation's value system in legal documents is the issue of goals in education law. Since the purpose of the education law is to determine the future development of the country, it is important to compare the goals and values of the new law with the goals of the previous law to determine the future development of the country. Therefore, in this study, the provisions defining the goals of the Law on Education (2002), the Law on Elementary and Secondary Education, and the General Law on Education, which was newly approved in 2023 and is currently in force, and the Law on Preschool and General Education were studied. Looking at the results of the comparative analysis of the provisions defining the purpose of the above laws, the categories included in the provisions of the law can be divided into two categories: values (roots) and declarations and principles. In the context of policy studies, values are calculated based on UNESCO's sustainable development education methodology. According to the results of the comparative content analysis, the goals of the education laws (2002/2023) should reflect the common values and declarations of humanity, and there is a need to include national and fundamental values in the law.

**Keywords:** Law of education · Goals · Fundamental values · Declaration of agreement

### Introduction

What kind of education is needed in the 21st century? What will be the purpose of education in the context of today's rapidly changing society? These questions were highlighted by Irina Bokova, former Director-General of UNESCO, in 2015 (UNESCO, 2015, p. 5). Bokova's inquiries emphasize the need to rethink the aims of education and training for the entire human race.

